



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2022 оны 08 дугаар сарын 26
№ 33 (1231)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 05 дугаар
сарын 05-ны өдөр

Дугаар 58

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Намсрайн Эрдэнэтуяаг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Эрдэнэцогтын Сарантогосыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 5 дугаар
сарын 11-ний өдөр

Дугаар 197

Улаанбаатар
хот

Журам, жагсаалт батлах тухай

Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 10.1.6-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээг байгуулах, ашиглах журам”-ыг 1 дүгээр хавсралт, “Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдох байгууллагын жагсаалт”-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тагнуулын ерөнхий газар (П.Одонбаатар)-т үүрэг болгосугай.

3.Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдож, мэдээ, мэдээллийг уг сүлжээгээр дамжуулж солилцох, ашиглах, аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга болон энэ тогтоолын хавсралтаар баталсан жагсаалтад дурдсан байгууллагын удирдлагад үүрэг болгож, холбогдох бусад төрийн байгууллагын дарга нарт зөвлөсүгэй.



4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам, жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 30 дугаар тогтоолын 1, 3 дугаар хавсралт, “Төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн 312 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ САЙДЫН
ҮҮРЭГ ХАРИУЦАГЧ**

Л.ЭНХ-АМГАЛАН

Засгийн газрын 2022 оны 197 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

ТӨРИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН СҮЛЖЭЭГ БАЙГУУЛАХ, АШИГЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг зүйл

1.1.Энэ журмын зорилго нь Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 10.1.6-д заасан жагсаалтад орсон байгууллагыг төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээ (цаашид “нэгдсэн сүлжээ” гэх)-нд холбох замаар байгуулах, ашиглах, тухайн байгууллагын сүлжээг нэгдсэн хамгаалалтад оруулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 4.1.17-д заасны дагуу нэгдсэн сүлжээ нь дараах 3 дэд сүлжээнээс бүрдэнэ:

1.2.1.кибер халдлага, зөрчлийг илрүүлэх, бүртгэх, таслан зогсоох, хяналт-шинжилгээ хийх, зохистой хэрэглээг бий болгох зорилго бүхий нэгдсэн хамгаалалтын системтэй интернэт сүлжээ (цаашид “төрийн интернэт хэрэглээний сүлжээ” гэх);

1.2.2.интернэтийн хязгаарлалттай хандалт бүхий төрийн албан хэрэглээний дотоод сүлжээ (цаашид “төрийн албан хэрэглээний сүлжээ” гэх);

1.2.3.төрийн нууцад хамаарах мэдээ, мэдээлэл солилцох зорилго бүхий мэдээллийн сүлжээ (цаашид “тусгай хэрэглээний сүлжээ” гэх).

1.3.Нэгдсэн сүлжээг зохион байгуулах, түүний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг Тагнуулын байгууллага (цаашид “зохицуулагч” гэх) хариуцна.

1.4.Нэгдсэн сүлжээний хэрэглэгч (цаашид “хэрэглэгч” гэх) нь “Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдох байгууллагын жагсаалт”-д орсон байгууллага байна.

Хоёр.Нэгдсэн сүлжээнд холбоход тавигдах шаардлага

2.1.Хэрэглэгч дараах ерөнхий шаардлагыг хангасан байна:

2.1.1.тоног төхөөрөмж, хэрэгслийг зохицуулагчаас өгсөн техникийн үзүүлэлтийн дагуу бэлтгэсэн байх;

2.1.2.тоног төхөөрөмж байршуулах зориулалт бүхий техникийн өрөө, орчин нөхцөлийг бүрдүүлж, хяналтын дүрс бичлэгийн төхөөрөмж (2 мегапиксель (1920x1080), 25 фрейм/секундээс багагүй техникийн үзүүлэлттэй) суурилуулсан байх;

2.1.3.Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 7.1-д заасан кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журамд нийцсэн дотоод журамтай байх;

2.2.Төрийн интернэт хэрэглээний сүлжээнд холбогдох хэрэглэгч нь энэ журмын 2.1-д зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

2.2.1.харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ, интернэтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчээс үйлчилгээ авдаг байх;

2.2.2.сүлжээнд шилэн кабелиар холбогдох дэд бүтэцтэй байх.

2.3.Төрийн албан хэрэглээний сүлжээнд холбогдох хэрэглэгч нь энэ журмын 2.1-д зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

2.3.1.төрийн интернэт хэрэглээний сүлжээнд холбогдсон байх;

2.3.2.сүлжээнд холбогдох сервер, компьютер, тоног төхөөрөмж болон тэдгээрээс хандах бусад сүлжээний хаяг, домэйн нэр, холбоосыг тодорхойлсон байх.

2.4.Тусгай хэрэглээний сүлжээнд холбогдох хэрэглэгч нь энэ журмын 2.3-т зааснаас гадна тухайн байгууллагын сүлжээний урсгалын багтаамж 10 Мегабайтаас багагүй хурдтай байх шаардлагыг хангасан байна.

Гурав.Нэгдсэн сүлжээнд холбох, ашиглах

3.1.Зохицуулагч нь хэрэглэгчийг нэгдсэн сүлжээнд холбох төлөвлөгөө баталж, хэрэгжүүлнэ.

3.2.Энэ журмын хоёрдугаар зүйлд заасан шаардлагыг хангасан хэрэглэгч нь нэгдсэн сүлжээнд холбогдох талаар дараах баримт бичгийг бүрдүүлж зохицуулагчид хүргүүлнэ:

3.2.1.интернэт сүлжээний зураглал, тоног төхөөрөмж, гадаад, дотоод сүлжээний хаягийн болон хостын мэдээлэл;

3.2.2.нэгдсэн сүлжээг хариуцан ажиллах ажилтны мэдээлэл.

3.3.Хэрэглэгч нэгдсэн сүлжээг өөрчлөх, шилжүүлэх, өргөтгөх, интернэтийн үйлчилгээ үзүүлэгчийг солих, интернэт сүлжээний хаяг өөрчлөх тохиолдолд зохицуулагчид ажлын 10 өдрийн өмнө мэдэгдэнэ.

3.4.Зохицуулагч нь энэ журмын 3.3-т заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор шийдвэрлэж, хариуг хүргүүлнэ.

3.5.Нэгдсэн сүлжээнд аливаа гэмтэл, саатал үүссэн тохиолдолд зохицуулагч, хэрэглэгч болон интернэтийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь өөрийн эзэмшил, ашиглалтад байгаа систем, тоног төхөөрөмжийн хүрээнд шалтгааныг тодорхойлж, хэвийн ажиллагаанд оруулах арга хэмжээг дангаар, эсхүл хамтран хэрэгжүүлнэ.

3.6.Шилэн кабелийн сүлжээгээр холбогдох боломжгүй, алслагдсан газарт байрлах хэрэглэгчийг хувийн нууцлалтай сүлжээ (VPN) ашиглан нэгдсэн сүлжээнд холбож болно.

3.7.Төрийн интернэт хэрэглээний сүлжээг энэ журмын 1.2.1, тусгай хэрэглээний сүлжээг 1.2.3-т заасан зорилгоор тус тус ашиглана.

3.8.Төрийн албан хэрэглээний сүлжээг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан нийтийн мэдээллийн системд холболт үүсгэж мэдээлэл солилцоход ашиглана.

Дөрөв.Нэгдсэн сүлжээнд оролцогчийн эрх, үүрэг

4.1.Зохицуулагч нь дараах эрхтэй байна:

4.1.1.нэгдсэн сүлжээний тоног төхөөрөмж, программ хангамжийн шинэчлэлт хийх тохиолдолд үйл ажиллагааг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь түр зогсоох;

4.1.2.энэ журмын хэрэгжилтийг хангуулахтай холбоотой асуудлаар хэрэглэгчид шаардлага тавих;

4.1.3.хэрэглэгчийн талд байрлах нэгдсэн сүлжээний систем, тоног төхөөрөмжийн тохируулгыг биечлэн болон зайнаас хийх;

4.1.4.хэрэглэгчээс нэгдсэн сүлжээний ашиглалттай холбоотой нэмэлт мэдээллийг гаргуулан авах;

4.1.5.“Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдох байгууллагын жагсаалт”-д нэмэлт, өөрчлөлт оруулах талаар санал боловсруулах.

4.2.Зохицуулагч нь нэгдсэн сүлжээг зохион байгуулж, түүний аюулгүй байдлыг хангахад дараах үүрэгтэй байна:

4.2.1.нэгдсэн сүлжээний кибер аюулгүй байдлыг хангах техник технологи, программ хангамжийг сайжруулах судалгаа, шинжилгээ хийж, хэрэгжүүлэх;

4.2.2.нэгдсэн сүлжээнд илэрсэн кибер халдлага, зөрчлийн мэдээллийн сан бүрдүүлэх, хяналт шинжилгээ хийх;

4.2.3.нэгдсэн сүлжээнд кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлийн түвшинг бууруулах арга хэмжээ авах;

4.2.4.нэгдсэн сүлжээний тоног төхөөрөмж, программ хангамжийн албан ёсны эрх, ашиглалт үйлчилгээний зардлыг шийдвэрлүүлэх;

4.2.5.нэгдсэн сүлжээний хэвийн, найдвартай ажиллагааг хангахад шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэгслийн нөөц бүрдүүлэх;

4.2.6.хэрэглэгч талд байрлах нэгдсэн сүлжээний систем, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг хангах асуудлаар мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

4.2.7.энэ журмын 4.1.1-д заасны дагуу нэгдсэн сүлжээний үйл ажиллагааг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь түр зогсоох тохиолдолд хэрэглэгчид энэ талаар ажлын 5 өдрийн өмнө мэдэгдэх.

4.3.Хэрэглэгч нь нэгдсэн сүлжээг ашиглах талаар дараах эрх, үүрэгтэй:

4.3.1.нэгдсэн сүлжээний кибер аюулгүй байдлыг хангах асуудлаар зохицуулагчаас мэргэжил, арга зүйн дэмжлэг авах;

4.3.2.нэгдсэн сүлжээний систем, тоног төхөөрөмжийн холболт, тохиргооны мэдээлэл алдагдахаас сэргийлэх;

4.3.3.нэгдсэн сүлжээнд холбоход шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэгсэл, шилэн кабелийн зардлыг шийдвэрлэх;

4.3.4.сүлжээний тоног төхөөрөмжийг шаардлагатай тохиолдолд зохицуулагчийн аюулгүй байдлын нэгдсэн удирдлагын системд оруулах;

4.3.5.нэгдсэн сүлжээнд холбогдсон систем, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг хангах;

4.3.6.систем, сүлжээний тоног төхөөрөмж нь кибер халдлага, зөрчилд өртсөн, гэмтэл саатал гарсан тохиолдолд зохицуулагчид даруй мэдэгдэх;

4.3.7.зохицуулагчаас өгсөн зөвлөмж, шаардлагыг хэрэгжүүлж, тухай бүр тайлагнах;

4.3.8.нэгдсэн сүлжээг хууль болон энэ журамд заасны дагуу ашиглах, түүний аюулгүй байдлыг хариуцах ажилтныг ажиллуулах.

Тав.Хориглох зүйл

5.1.Нэгдсэн сүлжээг ашиглахад дараах үйл ажиллагааг хориглоно:

5.1.1.зохицуулагчид урьдчилан мэдэгдэхгүйгээр нэгдсэн сүлжээний систем, тоног төхөөрөмжийг зориулалтын бусаар ашиглах, тохиргоог өөрчлөх;

5.1.2.хэрэглэгч нэгдсэн сүлжээнд нэвтрүүлсэн удирдлага, хамгаалалтаас зайлсхийх;



5.1.3.төрийн нууцад хамаарах мэдээ, мэдээллийг төрийн интернэт болон албан хэрэглээний сүлжээгээр дамжуулах.

Зургаа.Хариуцлага

6.1.Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

---о0о---

Засгийн газрын 2022 оны 197 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

ТӨРИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН СҮЛЖЭЭНД ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ

Нэг.Монгол Улсын Ерөнхийлөгч	
1.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар
2.	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба
Хоёр.Монгол Улсын Их Хурал	
3.	Улсын Их Хурлын Тамгын газар
4.	Үндэсний аудитын газар
5.	Үндэсний статистикийн хороо
6.	Монголбанк
7.	Хүний эрхийн Үндэсний комисс
8.	Төрийн албаны зөвлөл
9.	Санхүүгийн зохицуулах хороо
10.	Сонгуулийн ерөнхий хороо
Гурав.Монгол Улсын Засгийн газар	
11.	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
12.	Гадаад харилцааны яам
13.	Сангийн яам
14.	Хууль зүй, дотоод хэргийн яам
15.	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
16.	Батлан хамгаалах яам
17.	Боловсрол, шинжлэх ухааны яам
18.	Зам, тээврийн хөгжлийн яам
19.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
20.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
21.	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
22.	Барилга, хот байгуулалтын яам
23.	Эрчим хүчний яам
24.	Эрүүл мэндийн яам
25.	Соёлын яам
26.	Эдийн засаг, хөгжлийн яам
27.	Цахим хөгжил, харилцаа холбооны яам
Дөрөв.Хууль сахиулах байгууллага	
28.	Үндсэн хуулийн цэц
29.	Улсын ерөнхий прокурорын газар
30.	Авлигатай тэмцэх газар



31.	Шүүхийн ерөнхий зөвлөл
32.	Шүүхийн сахилгын хороо
33.	Улсын дээд шүүх
Тав.Засгийн газрын агентлаг, байгууллага, комисс	
34.	Тагнуулын ерөнхий газар
35.	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
36.	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
37.	Онцгой байдлын ерөнхий газар
38.	Улсын бүртгэлийн ерөнхий газар
39.	Оюуны өмчийн газар
40.	Зэвсэгт хүчний жанжин штаб
41.	Гаалийн ерөнхий газар
42.	Татварын ерөнхий газар
43.	Цагдаагийн ерөнхий газар
44.	Хил хамгаалах ерөнхий газар
45.	Архивын ерөнхий газар
46.	Боловсролын ерөнхий газар
47.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
48.	Гадаадын иргэн, харьяатын газар
49.	Нийгмийн даатгалын ерөнхий газар
50.	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
51.	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
52.	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар
53.	Иргэний нисэхийн ерөнхий газар
54.	Ашигт малтмал, газрын тосны газар
55.	Төрийн тусгай хамгаалалтын газар
56.	Үндэсний геологийн алба
57.	Усны газар
58.	Төрийн худалдан авах ажиллагааны газар
59.	Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн
60.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар
61.	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
62.	Цаг уур, орчны шинжилгээний газар
63.	Мал эмнэлгийн ерөнхий газар
64.	Жижиг, дунд үйлдвэрийн газар
65.	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар
66.	Стандарт, хэмжил зүйн газар
67.	Соёл, урлагийн газар
68.	Биеийн тамир, спортын улсын хороо
69.	Дотоодын цэргийн штаб
70.	Дотоод хэргийн их сургууль
71.	Цөмийн энергийн комисс
Зургаа.Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар	
72.	Нийслэлийн Засаг даргын тамгын газар
73.	Архангай аймгийн Засаг даргын тамгын газар
74.	Баянхонгор аймгийн Засаг даргын тамгын газар
75.	Баян-Өлгий аймгийн Засаг даргын тамгын газар
76.	Булган аймгийн Засаг даргын тамгын газар
77.	Говь-Алтай аймгийн Засаг даргын тамгын газар
78.	Говьсүмбэр аймгийн Засаг даргын тамгын газар
79.	Дархан-Уул аймгийн Засаг даргын тамгын газар
80.	Дорнод аймгийн Засаг даргын тамгын газар
81.	Дорноговь аймгийн Засаг даргын тамгын газар
82.	Дундговь аймгийн Засаг даргын тамгын газар
83.	Завхан аймгийн Засаг даргын тамгын газар



84.	Орхон аймгийн Засаг даргын тамгын газар
85.	Өвөрхангай аймгийн Засаг даргын тамгын газар
86.	Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газар
87.	Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газар
88.	Сэлэнгэ аймгийн Засаг даргын тамгын газар
89.	Төв аймгийн Засаг даргын тамгын газар
90.	Увс аймгийн Засаг даргын тамгын газар
91.	Ховд аймгийн Засаг даргын тамгын газар
92.	Хөвсгөл аймгийн Засаг даргын тамгын газар
93.	Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газар
Долоо.Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газрууд	
94.	Арабын Нэгдсэн Эмират Улсад суугаа ЭСЯ
95.	Бүгд Найрамдах Турк Улсад суугаа ЭСЯ
96.	Тайландын Хаант Улсад суугаа ЭСЯ
97.	Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад суугаа ЭСЯ
98.	Бельгийн Хаант Улсад суугаа ЭСЯ
99.	Бүгд Найрамдах Киргиз Улсад суугаа ЭСЯ
100.	Унгар Улсад суугаа ЭСЯ
101.	Бүгд Найрамдах Хятад Ард Улсад суугаа ЭСЯ
102.	Бүгд Найрамдах Польш Улсад суугаа ЭСЯ
103.	Америкийн Нэгдсэн Улсад суугаа ЭСЯ
104.	Бүгд Найрамдах Австри Улсад суугаа ЭСЯ
105.	Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад суугаа ЭСЯ
106.	Бүгд Найрамдах Куба Улсад суугаа ЭСЯ
107.	Бүгд Найрамдах Энэтхэг Улсад суугаа ЭСЯ
108.	Арабын Бүгд Найрамдах Египет Улсад суугаа ЭСЯ
109.	Австралийн Холбооны Улсад суугаа ЭСЯ
110.	Кувейт Улсад суугаа ЭСЯ
111.	Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсад суугаа ЭСЯ
112.	Оросын Холбооны Улсад суугаа ЭСЯ
113.	Бүгд Найрамдах Беларусь Улсад суугаа ЭСЯ
114.	Бүгд Найрамдах Казахстан Улсад суугаа ЭСЯ
115.	Канад Улсад суугаа ЭСЯ
116.	Бүгд Найрамдах Франц Улсад суугаа ЭСЯ
117.	Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсад суугаа ЭСЯ
118.	Бүгд Найрамдах Чех Улсад суугаа ЭСЯ
119.	Бүгд Найрамдах Итали Улсад суугаа ЭСЯ
120.	Бүгд Найрамдах Болгар Улсад суугаа ЭСЯ
121.	Бүгд Найрамдах Солонгос Улсад суугаа ЭСЯ
122.	Шведийн Хаант Улсад суугаа ЭСЯ
123.	Бүгд Найрамдах Сингапур Улсад суугаа ЭСЯ
124.	Япон Улсад суугаа ЭСЯ
125.	Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсад суугаа ЭСЯ
126.	Швейцарын Холбооны Улсад Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суугаа Байнгын төлөөлөгчийн газар
127.	Америкийн Нэгдсэн Улсад Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суугаа Байнгын төлөөлөгчийн газар
128.	Бүгд Найрамдах Турк Улс, Истанбул дахь Ерөнхий консулын газар
129.	Америкийн Нэгдсэн Улс, Сан Франциско дахь Ерөнхий консулын газар
130.	Япон Улс, Осака хот дахь Ерөнхий консулын газар
131.	Оросын Холбооны Улс, Кызыл дахь Ерөнхий консулын газар
132.	Оросын Холбооны Улс, Улаан-Үд дахь Ерөнхий консулын газар
133.	Оросын Холбооны Улс, Эрхүү дахь Ерөнхий консулын газар



134.	Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Хөх хот дахь Ерөнхий консулын газар
135.	Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Засаг захиргааны онцгой бүс Хонконг дахь Ерөнхий консулын газар
136.	Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Шанхай дахь Ерөнхий консулын газар
137.	Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Эрээн дахь Консулын газар
138.	Бүгд Найрамдах Солонгос Улс, Пусан дахь Консулын газар
139.	Америкийн Нэгдсэн Улс, Чикаго дахь Консулын газар
140.	Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Манжуур дахь Консулын газар
141.	Бүгд Найрамдах Казахстан Улс, Алматы дахь Консулын төлөөлөгчийн газар
142.	Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Тайвань дахь Улаанбаатар хотын Худалдаа, эдийн засгийн төлөөлөгчийн газар
Найм. Бусад	
143.	Харилцаа холбооны зохицуулах хороо
144.	“Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХК
145.	“Үндэсний дата төв” УТҮГ
146.	“И-Монгол академи” УТҮГ
147.	“Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв” УҮГ
148.	“Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК
149.	“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ
150.	“Замын хөдөлгөөний удирдлагын төв” НӨҮГ
151.	Монгол Улсын далайн захиргаа
152.	Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба
153.	“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ
154.	“Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулах нэгдсэн төв” УТҮГ
155.	“Хөрөнгийн бирж” ТӨХК
156.	Хадгаламжийн даатгалын корпораци
157.	“Монголын төмөр зам” ТӨХК
158.	“Улаанбаатар төмөр зам” ХНН
159.	Үндэсний Батлан хамгаалахын их сургууль
160.	Батлан хамгаалахын төв архив
161.	Соёлын өвийн үндэсний төв
162.	Монгол Улсын Шинжлэх ухааны академи
163.	“Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК
164.	“Чингис хаан” олон улсын нисэх буудал
165.	“Буянт-Ухаа” олон улсын нисэх буудал
166.	Нийслэлийн мэдээлэл, технологийн газар
Нийт 166 байгууллага	

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 0.75

Индекс: 200003